

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ  
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН  
ЗАХИРАМЖИЙН 2021 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН БИЕЛЭЛТ**

2021 оны 04 дүгээр сарын 30

Багануур дүүрэг

№	Ирсэн огноо	Батлагдсан огноо	Дугаар	Биелэлт
1.	2021.04.02	2021.04.02	A/246	<ul style="list-style-type: none"> <li>- Захирамжийн 6 дахь заалтын дагуу 03 дугаар сарын 31-ний өдрийн Даргын зөвлөлийн хурлаар нийт ажилтны 30%-ийг ажлын байранд бусад ажилтнуудыг байгууллагын үйл ажиллагааны хэвийн нөхцөл байдлыг алдагдуулахгүйгээр цахимаар ажиллуулахаар шийдвэрлэсэн.</li> <li>- Мөн нийт ажилтнуудад гэр-ажил мартшрутаар явах, шаардлагагүй бол гудамж талбай олон нийтийн газар болон худалдаа үйлчилгээний газраар явахгүй байх, цахимаар ажиллах албан хаагчдад ажил үүргээ цаг тухайд нь явуулж, халдвар хамгааллын дэглэмийг баримталж, айл хэсэхгүй, зочин урихгүй, шаардлагагүй тохиолдолд гэрээс гарахгүй байхыг үүрэг болгож ажилласан.</li> </ul>
2.	2021.04.09	2021.04.09	A/265	<p>Монгол Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан Захирамжийн 2.2 дахь заалтын хүрээнд 2021 оны 04 дүгээр сарын 10-25-ны өдрүүдэд ажиллах албан хаагчдын хуваарийг гаргаж Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын 2021 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 49 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын Хүний нөөцийн удирдлагын тасагт хүргүүлж хуваарийн дагуу байгууллагын үйл ажиллагааг алдагдуулалгүй ажилласан.</p>
3.	2021.04.02	2021.04.02	A/313	<ul style="list-style-type: none"> <li>- Захирамжийн 2 дахь заалтын дагуу “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ын хавсралтад өөрчлөлт орсон талаар албан хаагчдад танилцуулж, байгууллагын цахим хуудсанд байршуулан олон нийтэд түгээж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</li> <li>- Захирамжийн 6 дахь заалтын хүрээнд ажилчдыг ажлын байранд нь ажиллуулахгүйгээр цахимаар ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн ба төлөвлөгөөт албан бичгүүд илгээх зайлшгүй шаардлагаар ажлын байранд ирж ажиллах тохиолдолд ажлын үнэмлэхтэй, QR кодыг уншуулан, богино хугацаанд ажил үүргээ гүйцэтгэх зохион байгуулалтын арга хэмжээг авсан.</li> <li>- Захирамжийн 7 дахь заалтын дагуу албан хаагчдад өөрийгөө болон бусдыг эрсдэлд</li> </ul>



				оруулахгүй байхад анхаарч, зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд гэрээс гарахгүй байх, хамгийн ойр үйлчилгээний байгууллагаар хөдөлгөөн багатай үед үйлчлүүлэн, халдвар хамгааллын дэглэмийг сахихыг зөвлөж, үүрэг өгсөн.
--	--	--	--	--

ХЯНАСАН:

БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК  
ОНӨТҮГ-ЫН ДАРГА

Ч.ЭЛБЭГСАЙХАН



БИЕЛЭЛТ ГАРГАСАН:  
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э.ЭНХЗАЯА